



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/632

Булган сум

**Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх
2025 оны төлөвлөгөөт дархлаажуулалт
зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.7 дахь хэсэг, 9.8.1, 9.8.2 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.2, 28.4 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны "Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай" 225 дугаар тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/58 дугаар тушаалаар батлагдсан "Хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх заавар", "Хонины цэцэг өвчнөөс сэргийлэх амьд вакцины заавар", Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны А/264 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг Баяннуур, Дашинчилэн, Рашаант, Гурванбулаг, Могод, Сайхан сумдад 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс 14 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын төлөвлөгөөг 1 дүгээр хавсралт, шаардагдах зардлын тооцоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дархлаажуулалтад шаардагдах вакцин, био бэлдмэлийг татан авч сумдад хуваарилах, сумын мал эмнэлэг үйлчилгээний нэгжийг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн), орон нутагт зохион байгуулж, удирдлага, хүн, хүч, техник хэрэгсэл бусад шаардлагатай зүйлээр хангаж ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010877

Аймгийн Засаг даргын 2025 оны
..10 дугаар сарын 03-ны/ний өдрийн
..А/632 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

ХОНИНЫ ЦЭЦЭГ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛӨГӨӨ

д/д	Сумын нэр	Хамрагдах хонь	Вакцин		Шингэлэгч	
			Тун	Флкон	Литр	флкон
1	2	3	4	5	6	7
1	Баяннуур	41,000	41,000	410	41.00	164
2	Гурванбулаг	219,000	219,000	2,190	219.00	876
3	Дашинчилэн	109,600	109,600	1,096	109.75	439
4	Могод	270,400	270,400	2,704	270.25	1,081
5	Рашаант	138,800	138,800	1,388	138.75	555
6	Сайхан	182,600	182,600	1,826	182.75	731
	Дүн	961,400	961,400	9,614	961.50	3,846

ХОНИНЫ ЦЭЦЭГ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛДАН СЭРГИЙЛГЭХ ДАРХЛАЖУУЛАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Сумын нэр	Малын тоо	Явах км				Хүн хүн			
			Явах км	Шаардагдах шатахуун /литр/	Нэгж үнэ	Нийт үнэ	Туслах ажиглан	Өдөр	Томилолт	Нийт дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Баяннуур	41,000	950	100	2,760	276,000	2	15	1,800,000	2,076,000
2	Гурванбулаг	219,000	4,500	600	2,600	1,560,000	5	20	6,000,000	7,560,000
3	Дашинчилэн	109,600	2,500	300	2,700	810,000	5	15	4,500,000	5,310,000
4	Могод	270,400	980	250	2,700	675,000	5	20	6,000,000	6,675,000
5	Рашаант	138,800	545	220	2,700	594,000	2	15	1,800,000	2,394,000
6	Сайхан	182,600	950	240	2,700	648,000	4	20	4,800,000	5,448,000
	Бүгд	961,400	10,425	1,710	16,160	27,633,600	23	105	24,900,000	52,533,600

А/632 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт
 10 дугаар сарын 02-ны/ний өдрийн
 Аймгийн Засаг даргын 2025 оны

